



## ГААЛЬ, ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 02 дугаар  
сарын 24-ны өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Гаалийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.7 дахь хэсэг, Мэргэжлийн зөвлөлийн 2015 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

- 1.“Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 1 дүгээр,  
“Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 2 дугаар,  
“Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 3 дугаар,  
“Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 4 дүгээр,  
“Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим хэрэгжүүлэх журам”-ыг 5 дугаар хавсралтын ёсоор баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтийг зохион байгуулж, харьяа гаалийн газар, хороодыг удирдамж чиглэлээр хангаж ажиллахыг Гаалийн хяналт, бүрдүүлэлтийн газар /Б.Батгэрэл /-т үүрэг болгосугай.

3.Шинэчлэн батлагдсан гаалийн бүрдүүлэлтийн горимын кодыг CAIS системийн ангилалтын санд оруулахыг Мэдээллийн технологийн төв /Ш. Батзаяат/-д даалгасугай.

4.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гааль, татварын ерөнхий газрын даргын 2008 оны 676, 2009 оны 363, 2010 оны 330, 2011 оны 254, 2012 оны 136, А/67, А/221, А/205, А/69, А/235, 2013 оны А/77, А/250, 2014 оны А/89, А/131, 2015 оны А/13, А/209, 2015 оны А/263, А/283 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

С. ПҮРЭВ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 2016 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 3617 дугаарт бүртгэсэн.

**БАРААГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД  
ЗОРИУЛАН ОРУУЛАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 82-84 дүгээр зүйл, цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим сонгох, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, барааг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

**Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код**

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 83 дугаар зүйлд заасан барааг байршуулна.

2.2. Энэ журмын 2.1-д заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.

2.3. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах	400	шаардахгүй
2	Олон улсын гэрээний дагуу гаалийн болон бусад албан татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	401	Хилийн чанадаас оруулах бараанд шаардахгүй Бусад горимоос оруулах бараанд шаардана
3	Гадаад орны засгийн газар, олон улсын санхүүгийн байгууллагатай байгуулсан зээлийн гэрээний дагуу гаалийн болон бусад албан татвараас чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	402	Хилийн чанадаас оруулах бараанд шаардахгүй Бусад горимоос оруулах бараанд шаардана
4	Монгол улсын хуулийн дагуу гаалийн болон бусад албан татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж, дотоодын хэрэглээнд зориулан оруулах	403	Хилийн чанадаас оруулах бараанд шаардахгүй Бусад горимоос оруулах бараанд шаардана
5	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд	404	шаардахгүй

	зориулан оруулах валют, үнэт цаас		
6	Иргэний нисэхийн шатахуун:		
	-Замын-Үүд, Сүхбаатар боомтоор	405	шаардахгүй
	-Гаалийн баталгаат агуулахаас	406	700
7	Гаалийн болон бусад татвараас чөлөөлж оруулсан барааг гаалийн болон бусад татварыг төлүүлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	410	401-403
8	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах автобензин, дизелийн түлш:		
	Цагааннуур, Боршоо, Ярант, Тэс, Бургастай, Арцсуурь, Гашуун сухайт, Бичигт, Хавирга, Шивээхүрэн	411	шаардахгүй
	Ханх ,Ульханмайхан	412	шаардахгүй
	Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулаг	413	шаардахгүй
	Баянхошуу	414	шаардахгүй
	Эрэнцав	407	шаардахгүй
9	Хилийн чанадаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах гурил:		
	-Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Бургастай	417	шаардахгүй
	-Бусад боомт	418	шаардахгүй
10	Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах	420	500,508,512
11	Олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан гаалийн болон бусад татварыг төлүүлж оруулах	421	507
12	Гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулсан барааг гаалийн болон бусад татвараас чөлөөлж дотоодын хэрэглээнд зориулан оруулах	422	500,507,508,512,
13	Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулахаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	-тухайн барааг боловсруулсан, эсхүл баяжуулсан	431	561,571,581,591
	-тухайн бараагаар шинэ бүтэгдэхүүн	432	562,572,582,592

	үйлдвэрлэсэн		
14	Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	-тухайн барааг боловсруулсан, эсхүл баяжуулсан	441	501,521,531,541, 551
	-тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн	442	502,522,532,542, 552
	-тухайн бараанд засвар хийсэн	443	503,523,533,544, 554
	-тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашигласан	444	504,524,534,544, 554
15	Гаалийн баталгаат бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах:		
	-гаалийн баталгаат агуулахаас	451	700,703-709
	- гаалийн баталгаат үйлдвэрийн газраас	452	710,712-715
	-гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас	453	720,722-725
	-гаалийн баталгаат барилгын талбайгаас	454	730-734
	-гаалийн тусгай бүсээс	455	750-753,758-765
	-татваргүй барааны дэлгүүрээс	456	740,742,743
16	Гаалийн баталгаат бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах автобензин, дизелийн түлш:		
	-Цагааннуур, Боршоо, Ярант, Тэс, Бургастай, Арцсуурь, Гашуун сухайт	457	700
	-Ханх, Ульханмайхан	458	700
	-Эрэнцав, Замын-Үүд, Сүхбаатар, Алтанбулаг	459	700
17	Чөлөөт бүсээс дотоодын хэрэглээнд зориулан оруулах	460	770,771,774-778
18	Бүрдүүлэлтийн дараах шалгалтын үр дүнгээр	470	шалгалтын акт
19	Гаалийн баталгаат агуулахаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах гурил:		
	-Цагааннуур, Ярант, Боршоо, Арцсуурь, Бургастай	471	700
	-Бусад боомт	472	700
20	Барааг гаалийн бусад хяналтаас дотоодын хэрэглээнд зориулан оруулах	480	шаардахгүй

### Гурав. Бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, гадаад төлбөр тооцооны баримт;

3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;

3.1.3. гарал үүслийг нотлох баримт;

3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;

3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;

3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;

3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Мэдүүлэгч 3.1 дэх хэсэгт заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1 дэх хэсэгт заасан мэдээлэл, бичиг баримт нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдэг дарна.

### **Дөрөв. Горимын шаардлага**

4.1. Дотоодын хэрэглээнд зориулан оруулах бараанд гаалийн болон бусад татварыг ногдуулах бөгөөд энэ нь гаалийн болон бусад татвараас чөлөөлөгдөх бараанд нэгэн адил хамаарна.

4.2. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага барааг мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулахаас татгалзана.

4.3. Гаалийн байгууллагаас ногдуулсан гаалийн болон бусад татварыг бүрэн төлсөн, эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2 дахь хэсэгт заасны дагуу татвар төлөх баталгаа гаргасан тохиолдолд энэ горимын дагуу бүрдүүлэлт хийнэ.

4.4. Импортын гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдсөн барааг гаалийн байгууллагын зөвшөөрснөөс өөр зориулалтаар ашиглахыг хориглоно.

4.5. Энэ горимд байршуулах барааны гаалийн болон бусад татварыг ногдуулах, төлөх, хураан авах, баталгаа гаргуулах, буцаан олгохтой холбогдсон асуудлыг Гаалийн тариф, татварын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

4.6. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 420, 431, 432, 441-444 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд гаалийн болон бусад татварыг ногдуулж, өмнөх гаалийн мэдүүлгийг үндэслэн гаалийн болон бусад татварыг төлүүлэхгүй, төрийн сангийн тусгай дансад байршуулсан мөнгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

### **Тав. Бусад**

5.1. Барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горим нь барааг мэдүүлэгчид олгосноор, эсхүл өөр горимд байршуулснаар дуусгавар болно.

5.2. Горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас хураагдсан бол горимын үйлчлэл дуусгавар болсонд тооцно.

Гааль, татварын ерөнхий газрын даргын  
2016 оны А/40 дугаар тушаалын  
2 дугаар хавсралт

## БАРААГ ДОТООДЫН ХЭРЭГЛЭЭНД ЗОРИУЛАН БОЛОВСРУУЛАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим /Гаалийн тухай хуулийн 85-92 дугаар зүйл, цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горим сонгох, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, барааг горимд байршуулах, горим дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

### Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

- 2.1. Горимд гаалийн тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан барааг байршуулна.
- 2.2. Энэ горимд байршуулах бараанд монголын бараа хамаарахгүй.
- 2.3. Энэ журмын 2.1-дэх хэсэгт заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.
- 2.4. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулахад: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх	561 562	шаардахгүй
2	Хилийн чанадаас ирсэн гадаадын барааг дотоодын хэрэглээнд зориулан боловсруулахаар оруулсан хугацааг Гаалийн тухай хуулийн 89.2-т заасны дагуу сунгах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн	571 572	561,581,591 562,582,592

	үйлдвэрлэх		
3	Гаалийн баталгаат агуулахаас дотоодын хэрэглээнд зориулан боловсруулахаар оруулах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх	581 582	700,703,704, 706
4	Гаалийн тусгай бүсээс дотоодын хэрэглээнд зориулан боловсруулахаар оруулах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх	591 592	750-753,758-765

### Гурав. Бичиг баримт

- 3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.
- 3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, гадаад төлбөр тооцооны баримт;
- 3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;
- 3.1.3. гарал үүслийг нотлох баримт;
- 3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;
- 3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;
- 3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;
- 3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.
- 3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.
- 3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.
- 3.4. Гаалийн байгууллага Гаалийн тухай хуулийн 89.2-т зааснаар уг горимын хугацааг сунгасан тохиолдолд шинээр гаалийн мэдүүлэг бичүүлж горимын 571-572 кодоор бүрдүүлэлтийг хийнэ.
- 3.5. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Гаалийн хяналтад байгаа” хяналтын тэмдэг дарна.

### Дөрөв. Горимын шаардлага

- 4.1. Горимд байршуулах бараа нь Гаалийн тухай хуулийн 86 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.
- 4.2. Гаалийн тухай хуулийн 90 дүгээр зүйлд заасан зөвшөөрөл авсан хуулийн этгээд барааг энэ горимын дагуу оруулна.
- 4.3. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас хугацаа сунгах зөвшөөрөл олгосон тохиолдолд гаалийн мэдүүлэг шинээр бичүүлэх бөгөөд өмнөх гаалийн мэдүүлгийг хавсаргана.
- 4.4. Энэ журмын дагуу барааг тогтоосон хугацаанд буцаан гаргаагүй тохиолдолд тусгай дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг төсвийн орлогын дансанд шилжүүлэх тухай хавсралтаар батлагдсан загвар бүхий гэрээ байгуулан, гаалийн мэдүүлэгт хавсаргана.
- 4.5. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

4.6. Дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулсан барааг анх бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн, хугацаа дуусахад бусад горимд шилжүүлэн гаалийн бүрдүүлэлт хийж, хаалтын мэдээг сар бүр Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох хэлтэст ирүүлнэ. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас яаралтай тодруулах зорилгоор мэдээ тайлан гаргаж өгөхийг шаардсан тохиолдолд хугацаанд нь биелүүлнэ.

### **Тав. Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа**

5.1. Горимд байршуулах бараанд импортын гаалийн болон бусад татвар ногдуулж, хураан авч, тусгай дансанд төвлөрүүлнэ.

5.2. Горимд барааг байршуулахад гаалийн байгууллага импортын гаалийн болон бусад татвар төлөх баталгааг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т зааснаар гаргуулан авч болно.

5.3. Горимын дагуу боловсруулалт хийгдсэн бараа, бүтээгдхүүнийг дотоодын хэрэглээнд зориулан оруулахад ногдох татварыг тооцож, түр дансанд байршуулсан татварын зөрүүг буцаан олгоно.

5.4. Горимын дагуу оруулсан барааны хугацаа дууссан бол дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 36.2-т зааснаар түр дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

5.5. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т заасан баталгааг гаргаж дотоодын хэрэглээнд зориулан боловсруулах горимоор оруулсан барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор гаалийн бүрдүүлэлт хийлгээгүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.

5.6. Горимын эцсийн бүтээгдэхүүний гарал үүсэл нь импортоор түр оруулсан гадаадын барааны гарал үүсэлтэй байна. Хэрвээ тухайн гадаадын бараа нь 2 болон түүнээс дээш улсын гарал үүсэлтэй байвал импортын барааны гарал үүслийн дүрмийг баримтална.

### **Зургаа. Бусад**

6.1. Горимыг хэрэгжүүлэх явцад гарсан хаягдал, үлдэгдэлд мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

6.2. Горимыг хэрэгжүүлэх явцад бий болсон аливаа үлдэгдэл, хаягдлыг Гаалийн тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

Гааль, татварын ерөнхий газрын даргын 2016 оны А/40 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмын хавсралт

ГЭРЭЭ

\_\_\_оны\_\_\_сарын\_\_\_өдөр

Нэг талаас \_\_\_\_\_  
/мэдүүлэгч/

Гэрчилгээ \_\_\_\_\_ регистрийн № \_\_\_\_\_ мэдүүлэгч,



Нөгөө талаас \_\_\_\_\_ дахь гаалийн /газар, хороо/  
/гаалийн байгууллага/

нар \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр Гаалийн тухай хуулийн 89 дүгээр зүйлд заасан хугацаатайгаар энэ гэрээг байгуулав.

1. Мэдүүлэгч тогтоосон хугацаанд барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулах үүрэг хүлээнэ.

2. Гаалийн байгууллага бараа горимын шаардлага хангаагүй буцаан гаргасан тохиолдолд Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасан үүрэг хүлээнэ.

3. Мэдүүлэгч нь барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулах гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулаагүй, өөр зориулалтаар ашигласан тохиолдолд гаалийн байгууллага Татварын ерөнхий хуулийн 62.1.1-д заасны дагуу барааг оруулах үед түр дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг үл маргалдах зарчмаар төсвийн орлогын дансанд шилжүүлнэ.

Гэрээг хүлээн зөвшөөрсөн талууд:

Гаалийн байгууллага:  
Орлогч дарга.....

Мэдүүлэгч:  
.....

Тамга

Тамга

## БАРААГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ ТҮР ХУГАЦААГААР ОРУУЛАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим /Гаалийн тухай хуулийн 93-98 дугаар зүйл, цаашид “горим” гэх/-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Гадаадын бараанд өөрчлөлт оруулахгүйгээр хугацаанд нь буцаан гаргах нөхцлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим сонгох, бичиг баримтыг бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, барааг горимд байршуулах, горим дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

1.4. АТА, СПД карней бүхий бараа, тээврийн хэрэгслийг түр хугацаагаар оруулахад энэ журам хамаарахгүй.

### Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 94 дүгээр зүйлд заасан барааг байршуулна.

2.2. Горимд байршуулах бараанд монголын бараа хамаарахгүй.

2.3. Энэ журмын 2.1-д заасан бараа нь тарифын бус хязгаарлалтад хамаарна.

2.4. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах	500	шаардахгүй
2	Олон улсын гэрээ болон Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлж гаалийн нутаг дэвсгэрт түр оруулах	507	шаардахгүй
3	Барааг гаалийн баталгаат агуулахаас түр хугацаагаар оруулах	508	700,703,704, 706,707,709
4	Гаалийн бусад хяналтад байгаа барааг түр хугацаагаар оруулах	512	шаардахгүй

2.5. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 512 кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд гаалийн хяналтанд хамруулсан тухай бичиг баримтыг шаардана. Энэ бичиг баримтыг гаалийн мэдүүлэгт хавсаргана.

### Гурав. Бичиг баримт

3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.

3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, гадаад төлбөр тооцооны баримт;

- 3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;
  - 3.1.3. гарал үүслийг нотлох баримт;
  - 3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;
  - 3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;
  - 3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;
  - 3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.
- 3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.
- 3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.
- 3.4. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Гаалийн хяналтад байгаа” хяналтын тэмдэг дарна.

### **Дөрөв. Горимын шаардлага**

- 4.1. Барааг гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горимд дараах барааг байршуулж болохгүй.
- 4.1.1. арилжааны шинжтэй хүнсний бүтээгдэхүүн, согтууруулах ундаа, тамхи, түүхий эд, хагас боловсруулсан бүтээгдэхүүн, ашиглалтын явцад үрэгдэж үгүй болох бараа;
  - 4.1.2. үйлдвэрийн болон бусад хаягдал;
  - 4.1.3. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжуулан өнгөрүүлэхийг хориглосон бараа;
  - 4.1.4. гаалийн тэмдэглэгээ хийх боломжгүй, мөн гаалийн хяналт тавих боломжгүй бараа;
  - 4.1.5. гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар ашиглах зорилго нь тодорхой бус бараа.
- 4.2. Гаалийн байгууллага нь энэ горимд байршуулах бараанд гаалийн бүрдүүлэлт хийхдээ гаалийн тэмдэг, тэмдэглэгээ хийх, марклах, сорьц, дээж, загвар авах, бараа, тээврийн хэрэгслийн шинж байдлыг дэлгэрэнгүй тодорхойлон бичих, фото зураг авах, бичлэг хийх, бүдүүвч зураг гаргах зэрэг аргыг хэрэглэж файл үүсгэн CAIS системийн санд хадгалж, барааг гаалийн хилээр буцаан гаргахад оруулсан гаалийн мэдүүлэг болон гаалийн зорилгоор хийсэн дээрх тэмдэглэгээг нэг бүрчлэн шалгаж мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулна.
- 4.3. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 507 кодоор бүрдүүлэлт хийхэд Гааль, татварын ерөнхий газрын асуудал хариуцсан нэгжид түр хугацаагаар оруулах барааны жагсаалтыг ирүүлж шийдвэрлүүлнэ.
- 4.4. Горимд байршуулсан барааг буцаан гаргах хүртэлх хугацаанд анх гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн, хугацаа дуусахад зохих горимд шилжүүлэн байршуулж, гаалийн бүрдүүлэлт хийж, хаалтын мэдээг сар бүр Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох хэлтэст ирүүлнэ. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас яаралтай тодруулах зорилгоор мэдээ тайлан гаргаж өгөхийг шаардсан тохиолдолд хугацаанд нь биелүүлнэ.
- 4.5. Энэ журмын дагуу барааг тогтоосон хугацаанд буцаан гаргаагүй тохиолдолд тусгай дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг төсвийн орлогын дансанд шилжүүлэх тухай хавсралтаар батлагдсан загвар бүхий баталгаа гаргуулан, гаалийн мэдүүлэгт хавсаргана.
- 4.6. Барааг түр хугацаагаар оруулах талаар гаалийн байгууллагад баталгаа гаргасан этгээд нь гаалийн байгууллагын өмнө хуульд заасан үүрэг хариуцлагыг хүлээнэ.
- 4.7. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

### **Тав. Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа**

- 5.1. Гаалийн бүрдүүлэлтийн горимын 507-гоос бусад кодоор гаалийн бүрдүүлэлт хийхэд гаалийн байгууллагаас ногдуулсан гаалийн болон бусад татварыг хураан авч, тусгай

дансанд төвлөрүүлэх эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т зааснаар татвар төлөх баталгааг гаргасан байна.

5.2. Энэ горимд хамаарах барааны гаалийн болон бусад татварыг Гаалийн тариф, татварын тухай хуулийн 43.1-д заасан тохиолдолд буцаан олгоно.

5.3. Горимын дагуу оруулсан барааны хугацаа дууссан бол дотоодын хэрэглээнд зориулан оруулах горимоор гаалийн бүрдүүлэлт хийж, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 36.2-т зааснаар түр дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг улсын төсөвт төвлөрүүлнэ.

5.4. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т заасан баталгааг гаргаж түр хугацаагаар оруулсан барааг буцаан гаргаагүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.

Гааль, татварын ерөнхий газрын даргын  
2016 оны А/40 дугаар тушаалын 3 дугаар  
хавсралтаар батлагдсан журмын хавсралт

### БАТАЛГАА

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

/татвар төлсөн ААН, байгууллага, иргэний нэр, регистрийн №/  
гаалийн хилээр түр хугацаагаар оруулсан барааг Гаалийн тухай  
хуулийн \_\_\_\_\_ дугаар зүйлд заасан хугацаанд буцаан гаргаагүй эсхүл өөр горимд  
шилжүүлээгүй тохиолдолд \_\_\_\_\_ дугаар гаалийн мэдүүлгээр гаалийн болон  
бусад татварт төлсөн \_\_\_\_\_ төгрөг \_\_\_\_\_

/ татварын дүн үсгээр /

төгрөгийг төрийн сангийн тусгай данснаас улсын төсөвт үл маргах зарчмаар шилжүүлэхийг зөвшөөрч байна.

### БАТАЛГАА ГАРГАСАН:

.....  
/Албан тушаалын нэр,  
Тамга, тэмдэг/

/гарын үсэг/

.....  
/Албан тушаалтны нэр/

**БАРААГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БОЛОВСРУУЛАХ  
ГОРИМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горим /Гаалийн тухай хуулийн 99-107 дугаар зүйл, цаашид горим гэх /-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Гадаадын бараанд боловсруулалт хийж хугацаанд нь буцаан гаргах нөхцлөөр гаалийн нутаг дэвсгэрт түр хугацаагаар оруулах горим сонгох, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, барааг горимд байршуулах, горим дуусгавар болохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

1.4. “Засвар хийх” гэдэгт дараах үйл ажиллагаа хамаарна:

- тухайн барааны эвдэрч гэмтсэн хэсгийг засах,
- шинэчлэх,
- дутуу хэсгийг нөхөн гүйцээх, эсхүл
- барааг БТКУС-ийн ангиллын 8 оронгийн түвшинд ижил төрлийн өөр бараагаар солих.

**Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код**

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 101 дүгээр зүйлд заасан барааг байршуулна.

2.2. Энэ горимд байршуулах бараанд монголын бараа хамаарахгүй.

2.3. Горимд дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулж буцаан гаргах нөхцөлөөр түр оруулах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх -тухайн бараанд засвар хийх -тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	501 502 503 504	шаардахгүй
2	Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар түр хугацаагаар оруулсан хугацааг Гаалийн тухай хуулийн 104.2-т зааснаар сунгах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах	521 522	501,531,541,551 502,532,542,552 503,533,543,553 504,534,544,554

	-тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх -тухайн бараанд завсар хийх -тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	523 524	
3	Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар гаалийн баталгаат агуулахаас түр оруулах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх -тухайн бараанд завсар хийх -тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	531 532 533 534	700,703,704, 706,707,709
4	Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар гаалийн тусгай бүсээс түр оруулах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх -тухайн бараанд завсар хийх -тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	541 542 543 544	750-753, 758-765
5	Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар чөлөөт бүсээс түр оруюлах: -тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулах -тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх -тухайн бараанд завсар хийх -тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	551 552 553 554	770,771,774-778

### Гурав. Бичиг баримт

- 3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.
- 3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, гадаад төлбөр тооцооны баримт;
- 3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;
- 3.1.3. гарал үүслийг нотлох баримт;
- 3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;

3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;

3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;

3.1.7. технологийн бичиг баримт, түүнчлэн загвар, бараа тус бүрийн орц, материалын тооцоо;

3.1.8. шаардлагатай бусад бичиг баримт.

3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.

3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангаагүй бол гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.

3.4. Гаалийн байгууллага Гаалийн тухай хуулийн 104.2-т зааснаар уг горимын хугацааг сунгасан тохиолдолд шинээр гаалийн мэдүүлэг бичүүлж горимын 521-524 кодоор бүрдүүлэлтийг хийнэ.

3.5. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Гаалийн хяналтад байгаа” хяналтын тэмдэг дарна.

### **Дөрөв. Горимын шаардлага**

4.1. Барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахад Гаалийн тухайн хуулийн 99.2-т заасан үйл ажиллагаа хамаарна.

4.2. Горимд байршуулах бараа нь Гаалийн тухай хуулийн 100 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

4.3. Гаалийн удирдах төв байгууллагаас хугацаа сунгах зөвшөөрөл олгосон тохиолдолд гаалийн мэдүүлэг шинээр бичүүлэх бөгөөд өмнөх гаалийн мэдүүлгийг хавсаргана.

4.4. Горимын дагуу боловсруулалт хийх технологийн /аргачлал/ зааварчилгаанд барааг боловсруулах арга, үе шат, хугацаа, ямар засвар, өөрчлөлт оруулах, шинээр ямар бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах зэрэг боловсруулалтын үйл ажиллагааны тухай нарийвчлан тусгасан байна.

4.5. Мэдүүлэгч барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимоор байршуулах барааны орцын норм хэмжээг гаалийн байгууллагад гаргаж өгнө. Гаалийн байгууллага орцын нормын хэмжээг хянаж тогтооно. Орцын нормын хэмжээг тогтоохдоо мэргэжлийн байгууллагын туслалцаа авч болно.

4.6. Гаалийн байгууллага энэ горимын дагуу боловсруулалт хийдэг аж ахуйн нэгж болон экспортын гэрээг бүртгэхдээ материал зарцуулалтын тооцоо нийлэх хугацааг тэмдэглэж, хувийн дугаар бүхий тэмдэг дарж баталгаажуулна.

4.7. Материал зарцуулалтын тооцоогоо хугацаандаа хийгээгүй тохиолдолд тухайн аж ахуйн нэгжийн гаалийн хилээр нэвтрүүлэх дараагийн бараанд гаалийн бүрдүүлэлт хийхгүй.

4.8. Горимын дагуу боловсруулалт хийж буцаан гаргахдаа загварын альбом, материал зарцуулалтын тооцоог гаалийн бүрдүүлэлт хийхээс өмнө бэлэн болгосон байна.

4.9. Гаалийн байгууллагад урьдчилан мэдэгдэж бараанд боловсруулалт хийх үйл ажиллагааг өөр этгээдээр гүйцэтгүүлж болно.

4.10. Энэ журмын дагуу барааг тогтоосон хугацаанд буцаан гаргаагүй тохиолдолд тусгай дансанд байршуулсан гаалийн болон бусад татварыг төсвийн орлогын дансанд шилжүүлэх тухай 2 дугаар хавсралтаар батлагдсан загвар бүхий баталгаа гаргуулан, гаалийн мэдүүлэгт хавсаргана.

4.11. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

4.12. Гаалийн хяналтыг тасралтгүй тавих зорилгоор телекамерийг үйлдвэрлэл явуулж байгаа хэсэгт байршуулж, Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тухайн газар хороодтой холбоно.

4.13. Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах гаалийн бүрдүүлэлтийн горимд байршуулсан барааг анх гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн, хугацаа дуусахад бусад горимд шилжүүлэн гаалийн бүрдүүлэлт хийж, хаалтын мэдээг сар бүр Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох хэлтэст ирүүлнэ. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас

яаралтай тодруулах зорилгоор мэдээ тайлан гаргаж өгөхийг шаардсан тохиолдолд хугацаанд нь биелүүлнэ.

4.14. Гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимд байршуулах бараанд гаалийн байгууллага гаалийн зорилгоор тэмдэглэгээ хийнэ. Тэмдэглэгээг хийхдээ мөн хуулийн 261.1-д заасан тэмдэглэгээнээс аль тохирохыг нь сонгон хэрэглэнэ.

### **Тав. Гаалийн бүрдүүлэлтийн горимд мөрдөх баталгаа**

5.1. Гаалийн байгууллагаас ногдуулсан гаалийн болон бусад татварыг ногдуулж, хураан авч, тусгай дансанд төвлөрүүлэх эсхүл Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т зааснаар татвар төлөх баталгааг гаргасан тохиолдолд энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

5.2. Энэ журмын дагуу гадаадын захиалагчийн бараа материалаар бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж, үйлдвэрийн газар нь дараахь тохиолдолд ногдуулсан татварыг улсын төсөвт төвлөрүүлж, гаалийн бүрдүүлэлт хийнэ.

5.2.1. гэрээнд тусгасан нөхцөлийг бүрэн биелүүлээгүй, эсхүл гэрээ цуцлагдсан тохиолдолд хийсэн өөр гэрээгээ бүртгүүлээгүй, өмнөх гэрээгээр оруулсан барааны хугацаа сунгуулаагүй;

5.2.2. гэрээт бараа нь нэг захиалагчтай өөр үйлдвэрийн бараатай холилдон орж ирсэн болохыг импортын бараа авсан даруйд мэдэгдээгүй.

5.3. Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 41.2-т заасан баталгааг гаргаж гаалийн нутаг дэвсгэрт боловсруулах горимоор оруулсан барааг буцаан гаргаагүй тохиолдолд гаалийн болон бусад татварыг нөхөн төлүүлнэ.

### **Зургаа. Бусад**

6.1. Горимыг хэрэгжүүлэх явцад гарсан хаягдал, үлдэгдэлд мэдүүлэгчийн сонгосон гаалийн бүрдүүлэлтийн горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийнэ.

6.2. Горимыг хэрэгжүүлэх явцад бий болсон аливаа үлдэгдэл, хаягдлыг дотоодын хэрэглээнд зориулан оруулахаар гаалийн бүрдүүлэлт хийлгэх тохиолдолд дээрх үлдэгдэл, хаягдлыг тухайн байдлаар нь импортлоход импортын гаалийн болон бусад татвар ногдуулна.

6.3. Горимын барааг дотоодын хэрэглээнд зориулан оруулахад эцсийн бүтээгдэхүүний гарал үүсэл нь импортоор түр оруулсан гадаадын барааны гарал үүсэлтэй байна. Хэрвээ тухайн гадаадын бараа нь 2 буюу түүнээс дээш улсын гарал үүсэлтэй байвал импортын барааны гарал үүслийн дүрмийг баримтална.

Гааль, татварын ерөнхий газрын даргын  
2016 оны А/40 дугаар тушаалын 4 дүгээр  
хавсралтаар батлагдсан журмын хавсралт

### **БАТАЛГАА**

20 ... оны ... дугаар сарын ... өдөр

/татвар төлсөн ААН, байгууллага, иргэний нэр, регистрийн №/  
гаалийн хилээр барааг гаалийн нутаг дэвсгэрт боловсруулахаар оруулсан барааг  
Гаалийн тухай хуулийн \_\_\_\_\_ дугаар зүйлд заасан хугацаанд буцаан гаргаагүй  
эсхүл өөр горимд шилжүүлээгүй тохиолдолд \_\_\_\_\_ дугаар гаалийн мэдүүлгээр



гаалийн болон бусад татварт төлсөн \_\_\_\_\_ төгрөг \_\_\_\_\_

/ татварын дүн үсгээр /

төгрөгийг төрийн сангийн тусгай данснаас улсын төсөвт үл маргах зарчмаар шилжүүлэхийг зөвшөөрч байна.

БАТАЛГАА ГАРГАСАН:

.....  
/Албан тушаалын нэр,  
Тамга, тэмдэг/

/гарын үсэг/

.....  
/Албан тушаалтны нэр/

**БАРААГ ГААЛИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БУЦААН  
ОРУУЛАХ ГОРИМ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1. Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим /Гаалийн тухай хуулийн 108-112 дугаар зүйл, цаашид “горим” гэх /-ыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын гаалийн тухай хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ журмыг баримтална.

1.2. Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим сонгох, бичиг баримт бүрдүүлэх, татвар, хураамж ногдуулах, төлөх, хураан авах, барааг горимд байршуулах, горим дуусгавар болгохтой холбогдсон харилцааг энэ журмаар зохицуулна.

1.3. Горимыг мэдүүлэгч сонгох бөгөөд горимын нөхцөл, шаардлагыг хангасан тохиолдолд гаалийн байгууллагын зөвшөөрлөөр барааг уг горимд байршуулна.

1.4. Барааг хадгалах, барааны бүрэн бүтэн байдлыг хангах зорилгоор барааны дүнд өөрчлөлт оруулахгүйгээр засвар, техникийн үйлчилгээ хийсэн нь барааг энэ горимд байршуулахаас татгалзах үндэслэл болохгүй.

**Хоёр. Горимд байршуулах бараа, горимын код**

2.1. Горимд гаалийн тухай хуулийн 109.1 дэх заалтад заасан барааг байршуулна:

2.2. Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулахад дараах кодоор гаалийн бүрдүүлэлт хийнэ:

	Горимын утга	Бүрдүүлэлт хийх горимын код	Өмнөх бүрдүүлэлтийн горимын код
1	Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах	600	100,101,110, 120
2	Хилийн чанадад түр хугацаагаар гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах	610	200,210,
3	Хилийн чанадад боловсруулахаар гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах :		
	-тухайн барааг боловсруулах, эсхүл баяжуулахаар гаргасан	621	201,211
	-тухайн бараагаар шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр гаргасан	622	201,212
	- тухайн бараанд засвар хийхээр гаргасан	623	203,213
	- тухайн барааг өөр бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд ашиглах	624	204,214
4	Гаалийн баталгаат бүсийн горимд байршуулсан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах		
	- гаалийн баталгаат агуулахаас	631	701,702
	- гаалийн баталгаат үйлдвэрийн газраас	632	711
	- гаалийн баталгаат үзэсгэлэнгийн газраас	633	721

	- гаалийн тусгай бүсээс	634	754-757
	- татваргүй барааны дэлгүүрээс	635	741
5	Чөлөөт бүсийн горимд байршуулсан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах	640	772,773
6	Хилийн чанадад хууль бусаар гаргасан монголын барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах	641	шаардахгүй.

### Гурав. Бичиг баримт

- 3.1. Энэ горимын дагуу гаалийн бүрдүүлэлт хийхэд дараах бичиг баримтыг шаардана.
- 3.1.1. гадаад худалдааны гэрээ, эсхүл үнийн нэхэмжлэх, гадаад төлбөр тооцооны баримт;
- 3.1.2. тээврийн бичиг баримт / тээврийн баримт, баглаа боодлын жагсаалт, техникийн бичиг баримт гэх мэт/;
- 3.1.3. гарал үүслийг нотлох баримт;
- 3.1.4. эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, лиценз, сертификат;
- 3.1.5. гаалийн болон бусад татвараас бүрэн, эсхүл хэсэгчлэн чөлөөлөгдөх бол түүнийг баталгаажуулах эрх бүхий байгууллагын баримт;
- 3.1.6. лабораторийн шинжилгээний дүгнэлт /шаардлагатай тохиолдолд/;
- 3.1.7. шаардлагатай бусад бичиг баримт.
- 3.2. Мэдүүлэгч 3.1-д заасан бичиг баримтыг электрон шуудан, факс болон гаалийн байгууллагын мэдээллийн сүлжээгээр дамжуулан гаалийн байгууллагад ирүүлж болно.
- 3.3. Журмын 3.1-д заасан мэдээлэл, баримт бичиг нь горимын шаардлага хангахгүй байвал гаалийн байгууллага нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг шаардаж болно.
- 3.4. Энэ горимын дагуу байршуулах барааны гаалийн мэдүүлэгт гаалийн улсын байцаагч “Монголын гааль зөвшөөрөв” хяналтын тэмдэг дарна.

### Дөрөв. Горимын шаардлага

- 4.1. Гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах бараа монголын бараа болох нь нотлогдсон тохиолдолд тухайн бараанд импортын гаалийн болон бусад албан татвар ногдуулахгүй.
- 4.2. Хилийн чанадад бүрмөсөн гаргасан монголын бараанд хадгалалт, тээвэрлэлт, ашиглалтын ердийн нөхцөлд гарах элэгдэл хорогдлоос өөр бусад өөрчлөлт оруулахгүй.
- 4.3. Хилийн чанадад бүрмөсөн гаргасан бараанд энэ журмын 4.2-т зааснаас өөр өөрчлөлт орсон бол гадаадын бараа гэж үзэж, гаалийн бүрдүүлэлтийн өөр горимд байршуулан гаалийн болон бусад татварыг ногдуулан, хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.
- 4.4. Гаалийн байгууллага монголын барааг хилийн чанадад боловсруулах явцад гарсан боловсруулалтын зардал болон барааг хил хүргэх зардалд, мөн монголын барааг гадаадын бараатай нийлүүлж бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн бол гадаадын барааны үнийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан гаалийн үнийг тодорхойлох аргачлалын дагуу тодорхойлж, гаалийн болон бусад татварын ногдуулан хураан авч улсын төсөвт төвлөрүүлнэ.
- 4.5. Гаалийн байгууллага нь хилийн чанадад боловсруулахаар гаргасан барааг буцаан оруулахад шаардлагатай тохиолдолд шинжээчийн дүгнэлтийг гаргуулан авч болно.
- 4.6. Хилийн чанадад түр хугацаагаар гаргах болон хилийн чанадад боловсруулах горимд байршуулсан барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах хугацаа нь барааг уг горимд байршуулсан өдрөөс хойш 1 жилээс дээшгүй байх бөгөөд мэдүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллага 6 сар хүртэл хугацаагаар 1 удаа сунгаж болно.
- 4.7. Хилийн чанадад түр хугацаагаар болон боловсруулахаар гаргасан барааг хугацаанд нь буцаан оруулсан тохиолдолд өмнө нь гарахад төлж түр дансанд байршуулсан экспортын татварыг буцаан олгоно.

4.8. Хилийн чанадад бүрмөсөн гаргасан барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулахад экспортын татварыг буцаан олгохгүй.

4.9. Гаалийн хилээр бүрмөсөн гаргасан барааг өөр аж ахуйн нэгж, байгууллага болон хувь хүн буцаан оруулж ирж болно.

4.10. Энэ горимын дагуу бүрдүүлэлт хийхэд өмнө нь бүрдүүлэлт хийсэн гаалийн мэдүүлгийг шаардана.

4.11. Мэдүүлэгч нэмэлт мэдээлэл, бичиг баримтыг хуульд заасан хугацаанд гаргаж өгөх үүрэг хүлээх бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй бол гаалийн байгууллага мэдүүлэгчийн сонгосон горимд барааг байршуулахаас татгалзана.

4.12. Хилийн чанадад түр хугацаагаар гаргах гаалийн бүрдүүлэлтийн горимын барааг анх гаалийн бүрдүүлэлт хийсэн гаалийн байгууллага хяналт тавьж, тусгай бүртгэл хөтлөн, хугацаа дуусахад бусад горимд шилжүүлэн гаалийн бүрдүүлэлт хийж, хаалтын мэдээг сар бүр Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын холбогдох хэлтэст ирүүлнэ. Гаалийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас яаралтай тодруулах зорилгоор мэдээ тайлан гаргаж өгөхийг шаардсан тохиолдолд хугацаанд нь биелүүлнэ.

4.13. Монголын бараа болох нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бараанд горимын “641” кодоор бүрдүүлэлт хийхэд өмнөх гаалийн мэдүүлэг шаардахгүй.

### **Тав. Бусад**

5.1. Барааг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулах горим нь түүнийг гаалийн нутаг дэвсгэрт буцаан оруулснаар, эсхүл өөр горимд шилжүүлснээр дуусгавар болно.

5.2. Горимд байршуулсан бараа нь гаалийн зөрчлийн улмаас хураагдсан бол горимын үйлчлэл дуусгавар болсонд тооцно.